



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 10 сарын 01 өдөр

Дугаар Б/103


Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалт, Хөдөлмөрийн Тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалт, 24 дүгээр зүйл, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гончигжавын Цэнджавыг 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мэдээлэл технологийн инженерийн үүрэгт ажилд томилсугай.
2. Г.Цэнджавын сарын үндсэн цалинг 633221 (зургаан зуун гучин гурван мянга хоёр зуун хорин нэг) төгрөгөөр тогтоож, сар бүрийн цалингийн нэмэгдэл, хоол унааны зардлыг байгууллагын дотоод журамд нийцүүлэн олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг хүний нөөцийн менежер /Л.Мөнхтуяа/-д даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ